

**ОЛОН НИЙТИЙН СҮЛЖЭЭНД ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ
БОЛОН ДАГАЛДАН ГАРСАН ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ
ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, ТАТВАРЫН
ЕРӨНХИЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИУДАД
БҮХЭЛД НЬ ТАВЬСАН МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ХОРИГИЙГ ХЭЛЭЛЦСЭН ТАЛААРХ АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
САНАЛ, ДУГНЭЛТ**

2023 оны 03 дугаар
сарын 16-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч: Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр баталсан Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль болон дагалдан гарсан Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудад Монгол Улсын Ерөнхийлөгч 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр бүхэлд нь хориг тавьсан билээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 88 дугаар зүйлд заасныг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг тус Байнгын хорооны хуралдаанд Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар танилцуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан Улсын Их Хурал Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай болон Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу уг хуулийн төслийг хэлэлцэж баталсан бөгөөд холбогдох хуулийн заалтуудаас үзэхэд дээрх хууль тогтоомжийг зөрчсөн гэж үзсэн нь хэр үндэслэлтэй болох талаар ажлын хэсгээс тодруулан асууж, хариулт авлаа.


Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх олонх буюу 81.8 хувийн саналаар Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль болон дагалдан гарсан Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудад бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авах нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль болон дагалдан гарсан Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын еренхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудад бүхэлд нь тавьсан Монгол Улсын Еренхийлөгчийн хоригийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Б.ЭНХ-АМГАЛАН